



## МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2011 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

### Банкны эрх зүйн баримт бичгийг бүртгэх тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Монголбанкны Захирлуудын зөвлөлийн 2010 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Банкны эрх зүйн баримт бичгийг бүртгэх тухай журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэ журмыг 2011 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг бүх банк (Гүйцэтгэх захирал)-д даалгасугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн “Банкны эрх зүйн баримт бичгийг хянаж, бүртгэх журам” батлах тухай 1997 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 129 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Б.Лхагвасүрэн), Хуулийн хэлтэс (Г.Эрдэнэбаяр)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Л.ПҮРЭВДОРЖ

14 0099

## БАНКНЫ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ БҮРТГЭХ ТУХАЙ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 10, 12 дахь заалтын биелэлтийг хангах ажиллагааг тогтооход оршино.

1.2. Энэхүү журмыг банкнаас батлан гаргасан хэм хэмжээ тогтоосон шийдвэр /тушаал, дүрэм, журам, заавар/-ийг хүлээн авах, Монголбанкны банкны эрх зүйн актын бүртгэл /цаашид бүртгэл гэх/-д бүртгэх, түүнийг хадгалах, холбогдох мэдээлэл, лавлагааг Монголбанкны нэгж болон эрх бүхий байгууллагад өгөх үйл ажиллагаанд мөрдөнө.

1.3. Энэ журамд заасан нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1. “Банкны эрх зүйн баримт бичиг” гэж Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий банкнаас өөрийн үйл ажиллагаандаа мөрдүүлэхээр гаргасан, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй, гадагш чиглэсэн, хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг;

1.3.2. “Гадагш чиглэсэн” гэж тухайн банкны зөвхөн дотоод зохицуулалтын шинжийг агуулаагүй, харилцагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хэлцэл хийхдээ баримтлахаар журамласныг;

1.3.3. “Банкны удирдлагын үйл ажиллагаандаа, мөрдөх эрх зүйн баримт бичиг” гэдэгт банк үүсгэн байгуулах гэрээ, банкны дүрэм, банкны хувь нийлүүлэгчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн журам болон шийдвэр гаргах түвшинд зөвлөх, санал оруулах чиглэлээр зохион байгуулагдсан хороо, дэд хороо, зөвлөл зэрэг бүтэц зохион байгуулалтын нэгж (аудитын ба эрсдэлийн удирдлагын хороо, актив, пассивын удирдлагын хороо, зээлийн хороо, хяналт шалгалтын зөвлөл, хүний нөөцийн зөвлөл гэх мэт), гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх журмыг;

1.3.4. “Банкны үйл ажиллагааны эрх зүйн баримт бичиг” гэдэгт банкны үйл ажиллагааны тусгай зөвшөөрлөөр гүйцэтгэх гадагш чиглэсэн журам болон банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журмын зохицуулалтын хүрээнд банкны гүйцэтгэх удирдлага ба түүнээс дээш түвшинд зайлшгүй батлан гаргаж, үйл ажиллагаандаа мөрдвөл зохих эрх зүйн баримт бичгийг.

1.4. Банкны эрх зүйн баримт бичиг нь Банкны тухай хууль, Төв банк /Монголбанк/-ны тухай хууль болон бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан Монголбанкны эрх зүйн актын заалтад нийцсэн байх шаардлагыг Банк өөрөө хариуцна. Банкны шийдвэрийг дагаж мөрдүүлснээс үүсэх үр дагаврыг шийдвэр гаргасан банк хариуцна.

## **Хоёр. Эрх зүйн баримт бичгийг хүлээн авах, бүртгэх**

2.1. Банк нь эрх зүйн баримт бичгийн хоёр хувь /албан ёсны эх хувь, түүний баталгаажуулсан хуулбарын нэг хувь/-ийг баталсан тухай тушаалын хамт, түүнийг баталснаас хойш ажлын 10 өдрийн дотор Монголбанкны Хуулийн хэлтэс /цаашид Хуулийн хэлтэс гэх/-т албан бичгээр, эсхүл урьдчилж бичгээр мэдэгдсэн цахим хаягаас цахим хэлбэрээр ирүүлнэ.

2.2. Дээр дурдсан эрх зүйн баримт бичгийг хоёр буюу түүнээс дээш банк, өөр байгууллагатай хамтарч уг эрх зүйн баримт бичгийг гаргасан бол тухайн баримт бичигт нэр эхлэн бичигдсэн банк, байгууллага хариуцан мөн хугацааны дотор Хуулийн хэлтэст ирүүлнэ.

2.3. Банкны эрх зүйн баримт бичгийг бүртгүүлэхээр хүргүүлж байгаа этгээд нь энэ журмын 2.1-д заасан материалын бүрдлийг хангаагүй тохиолдолд Хуулийн хэлтэс хүлээн авахаас татгалзана.

2.4. Банкны эрх зүйн баримт бичиг нь энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангаж байгаа бол түүний албан ёсны эх хувь дээр Монголбанкны бүртгэлд бүртгэсэн тухай тусгай тэмдэглэл хийж баталгаажуулан Хуулийн хэлтэст хадгална. Бүртгэсэн тухай албан бичиг болон бүртгэлийн дугаар олгож, тэмдэглэл хийсэн шийдвэрийн баталгаажуулсан хуулбарыг тухайн этгээдэд, хамтарч баталсан бол бүх этгээдэд хүргүүлнэ.

2.5. Хэм хэмжээ тогтоогоогүй шийдвэр ирүүлсэн тохиолдолд Хуулийн хэлтэст бүртгэх шаардлагагүй тухай хариу мэдэгдэж буцаан хүргүүлнэ.

2.6. Банк нь бүртгүүлсэн шийдвэртээ нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах болон хүчингүй болгосон тохиолдол бүрт холбогдох тушаалын хамт баталснаас хойш ажлын 5 өдрийн дотор Хуулийн хэлтэст ирүүлж бүртгүүлнэ.

## **Гурав. Бүртгүүлбэл зохих эрх зүйн баримт бичиг**

3.1. Банк нь дараахь эрх зүйн баримт бичгийг Хуулийн хэлтэст бүртгүүлнэ:

3.1.1 Энэ журмын 1.3.3–т заасан банкны гүйцэтгэх удирдлага болон түүнээс дээш түвшинд мөрдөх эрх зүйн баримт бичиг;

3.1.2 Энэ журмын 1.3.4–т заасан банкны бусад буюу гүйцэтгэх удирдлагаас доош түвшинд мөрдөх харилцааг зохицуулсан эрх зүйн баримт бичиг;

3.1.3 Монголбанк шаардлагатай гэж үзсэн бусад эрх зүйн баримт бичиг.

3.2. Хуулийн хэлтэс нь бүртгэлд бүртгэгдсэн эрх зүйн баримт бичгийн тухай Хяналт шалгалтын газрын бичиг хэрэг эрхэлсэн ажилтанд цахим шуудангаар мэдэгдэнэ.

## **Дөрөв. Эрх зүйн баримт бичгийг хадгалах, түүнийг ашиглах**

4.1. Хуулийн хэлтэс нь банкны бүртгүүлсэн эрх зүйн баримт бичгийн хуудас бүрийн баруун дээд өнцөгт бүртгэгдсэн огноо, бүртгэлийн дугаарыг тэмдэглэн банк тус

бүрээр нь файл болгож, товъёоглон хадгална. Хамтарсан эрх зүйн баримт бичгийг хамтарсан баталсан банк ба банк бус санхүүгийн байгууллага тус бүрийн файлд хадгалах бөгөөд бүртгэлийн дугаар нь нэг байна.

4.2. Банкны эрх зүйн баримт бичгийн бүртгэл, мэдээллийн санг Хуулийн хэлтсээс эрхлэх бөгөөд түүнд байгаа мэдээллийг зөвхөн Монголбанкны нэгжийн ажлын хэрэгцээ болон банкны тогтолцооны хүрээнд бодлого боловсруулахад шаардлагатай судалгаа, шинжилгээний зорилгоор ашиглана.

4.3. Банк нь Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 311 дүгээр тушаалаар батлагдсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ын дагуу Монголбанкинд бүртгүүлсэн эрх зүйн баримт бичгийн тухай олон нийтэд мэдээлнэ.

4.4. Банк нь түүний эрх зүйн баримт бичгийг бүртгэж, бүртгэлийн дугаар олгосон тухай албан бичгийг огноолсон өдрөөс хойш ажлын 2 өдрийн дотор өөрийн цахим хуудаст холбогдох мэдээллийг олон нийтэд зориулж байршуулна.

#### **Тав. Хариуцлага**

5.1. Энэхүү журмыг биелүүлээгүй тохиолдолд тухайн банк нь Банкны хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.2. Хуулийн хэлтэс банкны эрх зүйн баримт бичгийн бүрэн, бүтэн байдлыг хариуцаж, нууцлалыг чанд сахина. Хуулийн хэлтэс шаардлагатай гэж үзвэл банкинд эрх зүйн актын хуульд нийцэж буй эсэх талаар зөвлөмжийг хүргүүлж болно.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_